

## АГУУЛГА

<b>ОРШИЛ</b> .....	<b>2</b>
<b>БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	<b>3</b>
<b>БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЦ ТАНИЛЦУУЛГА</b> .....	<b>10</b>
<b>БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> ..	<b>12</b>
<b>БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ</b> .....	<b>15</b>
<b>БҮЛЭГ V. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>18</b>
V.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	18
V.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	22
V.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
V.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	23
V.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	24
V.6. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд.....	24
V.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	24
V.8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	25
V.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	27
V.10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	28
V.11. БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь.....	29
<b>ГОЛ ҮР ДҮН БА ДҮГНЭЛТ</b> .....	<b>31</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b> .....	Error! Bookmark not defined.

## ОРШИЛ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хагаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь Цоохор морьтын Дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй Алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм, журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Эрхэсмайнинг” ХХК нь мөрдөж ажиллана.

Цоохор морьтын Дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй Алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдснөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

Тус төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу “сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Цоохор морьтын дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй Алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн эхний жилийн БОМТ-нд нийт 22,595,000 төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

## БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### I.1. Төслийн ерөнхий мэдээлэл

**Тайлангийн нэр:** Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хэрэгжих Цоохор морьтын Дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй Алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр		“Эрхэсмайнинг” ХХК
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар		9011012036
3	Ордын нэр		Цоохор морьтын дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй алтны шороон орд
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Булган
5		Сум/Дүүрэг	Бүрэгхангай
6	Ашигт малтмалын төрөл		Алт
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар		MV-019852
8	Ашиглалт эхэлсэн огноо		-
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Хан-Уул
11		Баг/Хороо	17-р хороо
12		Гудамж/Байр	Кинг тауэр 126-150 тоот
13		Утас	99113931
14	Захирлын хаяг	Нэр	Д.Баяраа
15		Цахим шуудан	<a href="mailto:erkhesmining@gmail.com">erkhesmining@gmail.com</a>
16		Утас	99113931

**Төслийн байршил:** Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн нутаг дэвсгэрт Улаанбаатар хотын төвөөс баруун зүгт 449 км, Бүрэгхангай сумын төвөөс зүүн хойш 70 км зайд, Орхонтуул сумын төвөөс баруун урагш 32 зм зайд байрладаг.

Талбайн нэр: Ар тамсаг-1-2


Трапецын номенклатур: М-48-126

Талбайн нийт хэмжээ: 302.3 га

Хүснэгт 2. Төслийн талбайн координатын солбицолын цэг

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	104	32	9.54	48	37	59.85
2	104	32	9.54	48	37	58.61
3	104	32	10.64	48	37	58.61
4	104	32	10.64	48	37	57.52

5	104	32	11.56	48	37	57.52
6	104	32	11.56	48	37	56.74
7	104	32	13.02	48	37	56.74
8	104	32	13.02	48	37	55.31
9	104	32	14.23	48	37	55.31
10	104	32	14.23	48	37	54.73
11	104	32	15.39	48	37	54.73
12	104	32	15.39	48	37	53.57
13	104	32	16.53	48	37	53.57
Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
14	104	32	16.53	48	37	52.76
15	104	32	18.01	48	37	52.76
16	104	32	18.01	48	37	51.36
17	104	32	19.2	48	37	51.36
18	104	32	19.2	48	37	50.56
19	104	32	20.69	48	37	50.56
20	104	32	20.69	48	37	49.34
21	104	32	22.05	48	37	49.34
22	104	32	22.05	48	37	48.25
23	104	32	23.61	48	37	48.25
24	104	32	23.61	48	37	46.76
25	104	32	24.99	48	37	46.76
26	104	32	24.99	48	37	45.97
27	104	32	26.47	48	37	45.97
28	104	32	26.47	48	37	45.3
29	104	32	21	48	37	46
30	104	32	24.6	48	37	37.85
31	104	32	20.99	48	37	37.85
32	104	32	20.98	48	36	41.85
33	104	32	45.98	48	36	41.85
34	104	32	45.98	48	36	17.96
35	104	31	31.98	48	36	17.96
36	104	31	31.99	48	37	27.85
37	104	31	55.98	48	37	27.85
38	104	31	55.98	48	37	59.85




Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн сансрын байр зүйн зураг

**Орд ашиглах тусгай зөвшөөрөл:** Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дахь “Ар тамсаг-1-2” нэртэй 302.3 га талбайд ашигт малтмал ашиглалтын MV-019852 тоот тусгай зөвшөөрлийг “Эрхэсмайнинг” ХХК нь 2004 оны 12 дугаар сарын 08-нд шилжүүлэн авсан байна.

**Ашиглалтын системийн сонголт:** Ордын хөрс хуулалт болон элс олборлолтын ажлыг авто тээвэртэй дотоод овоолготой ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ.

**Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, түүний хүрээн дэх геологийн нөөц:** Цоохор морьтын дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” алтны шороон орд нь III бүлгийн орд тул уурхайн эцсийн хүрээ хязгаар нь бодитой В нөөцийг бүрэн буюу 76.28 мян.м<sup>3</sup> элс /37.45 кг металл хими цэвэр/ ашиглахаар байна.

2017 онд хийгдсэн хайгуулын ажлаар тусгай зөвшөөрлийн талбайд бие биеэсээ салангид орших 3 биет орд байна.



I биетийг ашиглах ил уурхай нь баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон ба амсрын өргөн 115 м, урт 340 м, гүн 20 м, уурхайн ёроолын өргөн 40-50 м, урт 300 м байна.

II биетийг ашиглах ил уурхай нь баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон ба амсрын өргөн 100 м, урт 520 м, гүн 12 м, уурхайн ёроолын өргөн 50-80 м, урт 500 м байна.

III биетийг ашиглах ил уурхай нь баруун урдаас зүүн хойш сунаж тогтсон ба амсрын өргөн 120 м, урт 625 м, гүн 25 м, уурхайн ёроолын өргөн 40-80 м, урт 575 м байна.

Зураг 2. Ил уурхайн нөөцийн дэвсгэр зураг

**Үйлдвэрлэлийн нөөц:** Ил уурхайн хүрээнд бодитой В зэргээр нийт 76.28 мян.м<sup>3</sup> элс, элсэн дэх металлын хэмжээ химийн цэврээр 37.45 кг байна. Үүнээс ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц хаягдал бохирдол тооцсоны дараах байдлаар, В’ – зэргээр 95.9 мян.м<sup>3</sup> элс олборлох ба металлын хэмжээ химийн цэврээр 37.08 кг байна.

## I.2. ТУХАЙН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ХУРААНГУЙ

**Ордын нээлт:** Ар тамсаг-1-2 алтны шороон ордыг нээхэд II биетийн урд хэсгийн В-8 блок буюу Х=465714.02, Y=5384807.56 цэгт, 12 м зузаан хөрсийг урдаас хойш чиглэлд хуулснаар элсний доголд хүрч элс олборлолтын ажил явуулахад бэлэн болж нээгдэнэ. Элс олборлолтын ажлыг эхлэхийн тулд 28.0 мян.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийх ба нээлтээс гарсан хөрсийг ил уурхайн урд хэсэгт түр овоолго үүсгэн байршуулж уулын ажил өрнөсний дараа ил уурхайн сул орон зайд дотоод овоолгод буцаан байршуулна.

**Уурхайн жилийн хүчин чадал:** Уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажлыг дулааны улиралд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. Ил уурхайн элс орборлолт эхний жилд 45.9 мян.м<sup>3</sup> байна.

**Уулын ажлын горим:** Уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан дулааны улиралд хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар байна. Уурхайн нь жилд цэвэр 150 хоног ажиллана.

**Ашиглалтын технологи:** Тус ордыг эцсийн гүн хүртэл ил уурхайгаар дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, суналын дагуу баруун урдаас зүүн хойш гэсэн уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ.

Хөрс хуулалт болон элс олборлолтын ажлыг экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн ашигласан орон зайд дотоод овоолго үүсгэх, олборлосон элсийг шороон ордын угаах төхөөрөмж рүү 0.8 км зайд тээвэрлэн угаана.

**Баяжуулалтын технологи:** Элс угаан баяжуулах технологийг хоригт цоргоор хаягдаж буй нарийн ширхэглэлтэй алтыг баяжуулж авах зорилгоор хоригт цорго баяжуулах ширээ-төвөөс зугтах хүчний сепараторын хослолоор баяжуулна.

Элс угаах тоног төхөөрөмжийн хувьд компанийн эзэмшилд буй хүндийн хүчээр ангилан ялгах скруббер болон хоригт цоргоны хослол болох 1 ширхэг СБ-80 маркийн угаах төхөөрөмж, гүйцээн баяжуулалтад баяжуулах ширээ, чичиргээт шигшүүр, төвөөс зугтах хүчний сепаратор, хөдөлгөөнт хоригт цорго гэсэн үндсэн тоног төхөөрөмжийг ашиглана.

Элсний том ангилалд байгаа наалдцыг усаар угаан шигшиж ангилсны дараа алт агуулсан нарийн ширхэгтэй ангиллыг хоригт цоргоор баяжуулан алттай шлихийг ялгаж авна. Хоригт цоргоноос гарах эфелийг ширхэглэлээр нь ангилан 0-2мм ширхэглэлтэй элсийг төвөөс зугтах хүчний сепаратороор, 2-5 мм-ийн ширхэглэлтэй элсийг хөдөлгөөнт хоригт цоргоор баяжуулна. Угаах төхөөрөмжөөс ялгасан шлихийн баяжмалыг гүйцээн боловсруулах цехэд боловсруулна. Гүйцээн ялгалтыг баяжуулах ширээгээр баяжуулах ба дараа нь соронзонгоор хар шлихийг ялгаж цахилгаан зуухан дээр хатааж, тороор шигшин ангилж, ангилал тус бүрийг үлээн ялгана.

### **I.3. Төслийн бусад мэдээлэл, дэд бүтцийн хураангуй**

**Ажиллах хүч:** Уурхайд дунджаар 48 хүн ажиллах бөгөөд үүнд компаний захирал, уурхайн дарга, нягтлан бодогч, нууцын эрхлэгч, ХАБЭА инженер, геологич, байгаль орчны мэргэжилтэн, уулын мастер, баяжуулах инженер, ил уурхайн ажилчид, баяжуулах хэсгийн ажилчид, цахилгаанчин, засварчин, гагнуурчин болон бусад гэсэн орон тооны бүрэлдэхүүнтэй ажиллана.

#### **Уурхайн дэд бүтэц:**

**Цахилгааны эрчим хүчний эх үүсвэр** - дизель цахилгаан үүсгүүр ашиглана.

**Дулаан хангамж** - цахилгаан халаагуур ашиглана.

**Усан хангамж** - Уурхайн ундны усны хэрэглээг “Өгөөж баян хангай” ХХК-ийн өрөмдмөл худгийн уснаас хангана. Технологийн усны хэрэгцээг Туул голын гадаргын уснаас хангана.

**Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа** - Ажиллагсдын тосгон болон уурхайн захиргаа зэргийг тусгай зөвшөөрлийн талбай дотор 2-р биетээс баруун зүгт 0.5 км, 2 болон 3 биетээс чанх урагш 2 км зайд шинээр байгуулна. Энд хоолны газар, халуун ус, эмнэлгийн цэг байна.

Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг хийх, зөвлөгөө өгөх, анхны тусламж үзүүлэх эмийн сан бүхий цэг, эмчийн хувьд уурхай дээр орон тооны 1 бага эмч ажиллана.

Уурхайн барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын өрөө, ажлын даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар, уурхайн ажиллагсдын цайны газар, авто машины засварын газар зэрэг барилга байгууламж нь уурхайн тосгон дотор байрлана.

Засварын газар - тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлнэ.

Зам тээвэр, харилцаа холбоо - дотоод замууд нь байнга усалгаа арчилгаатай уурхайн зориулалтай шороон зам байна. Уурхайн ойролцоох төв суурин газрууд нь харилцаа холбоо өндөр хөгжсөн бүсэд хамрагдана. Уурхайн дэргэд үүрэн телефоны үндэсний байгуулга болох мобиком, жимобайл зэрэг сүлжээ ажилладаг.

#### **Хог хаягдал:**

Хатуу хог хаягдал - Уурхайгаас гарах ахуйн гаралтай хатуу хаягдлын эх үүсвэр нь ажилчдын хэрэглээ, хоол бэлтгэлийн явц байх болно. Уурхайн үйл ажиллагаанаас хүнсний зүйлсийн сав, баглаа боодол, бие засах газрын хаягдал, ундааны сав, лааз болон бусад хаягдал, хоолны үлдэгдэл болон бусад болно.

Ил уурхайд хоногт нэг хүнээс 0.41 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол нийт 48 хүн \* 0.41 кг \* 150 хоногт буюу жилд 2,952 кг орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

Ахуйн гаралтай хог хаягдлыг цуглуулах тусгайлан бэлтгэсэн хогийн түр хураах цэг байгуулах бөгөөд тус хураах цэгт таглаа битүүмжлэл сайтай хогийн савуудыг байрлуулна. Хог хаягдлын цэгийг салхины зонхилох чиглэлийн доор тогтсон нэг цэгт байрлуулж, уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг тухай бүр ариутгаж, овор хэмжээг нь багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг багасгах хэрэгтэй.

Ахуйн шингэн хаягдал - Уурхайн үйл ажиллагаанаас ахуйн шинжтэй шингэн хаягдал /хоол хүнсний хаягдал, угаалга, цэвэрлэгээ, бие засах газрын хаягдал бохир ус зэрэг/ гарна.

Аюултай хаягдал - Төсөлд хэрэглэгдэх тос тосолгооны материал, түлш маслыг тусгай зориулалтын складанд хадгална. Тос тосолгооны материалыг солиход үлдсэн хаягдал тос, маслыг тусгай саванд шүүж авч, дахин ашиглана. Шүүж авахдаа тос тосолгооны материалыг асгаруулахгүй. Шүүж авсан тосолгооны материалаа хаягдал тос авдаг үйлдвэрт худалдаална.

Хийн хаягдал - Тээврийн хэрэгслийн олборлолтын явцад ашиглах дизелийн түлш, бензин нь химийн гаралтай хорт хийн хаягдал болж агаар орчныг бохирдуулна. Хүнд даацын автомашины хөдөлгөөн овоолгод шороо зөөх, тээвэрлэх үйл ажиллагааны үед агаарт

их хэмжээний тоос шороо дэгдэж, хүнд машин механизмын хөдөлгүүрээс утаа тортог, хорт бодис ихээр ялгардаг. Энэ нь агаар орчныг бохирдуулах, ажиллагсдын эрүүл мэнд болон орчны хөрс, ургамлын бүрхэвчид муугаар нөлөөлөх магадлалтай.

## БҮЛЭГ II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЦ ТАНИЛЦУУЛГА

### II.1. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Цоохор морьтын дэнжийн хэсэг дэх “Ар тамсаг-1-2” нэртэй алтны шороон орд нь газарзүйн байршлаараа Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт Туул голын хөндийн зүүн талд Цоохор морьтын Дэнжийн хэсэгт 302.3 га талбайд оршино.

**Ландшафт:** Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Орхон-Сэлэнгэ мөрний сав гарын дундаж ба нам уулын муж, Орхон-Туул голын сав газрын нам уул, хотгор бүхий хуурай хээрийн дэд муж, Бургалтайн умардын хуурай хээр, ойт хээрийн бүсэд хамаарна.

**Байгалийн мужлал:** Тус мужийн чийгээр элбэгжүү баруун хойт хэсгийн хөндий хотгороор нунтаг карбонатлаг хар шороон хөрстэй, алаг өвс-үетэнт ургамалшил бүхий жижиг бутлаг үетэнт хээрийн ландшафт бүрэлдэн тогтсон. Хотгоруудын ёроолд нуга, элсний ландшафт, мараа-марзат хам бүрдэл, нарсан төгөл тогтворжсон байна.

**Физик газарзүй:** Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэг, Туул голын хөндийн хэсгийг хамарч байрлана. Энэ нутаг дэвсгэрт намхан уулсын гадаргуу зонхилдог ба энэ нь дунд уулсыг эмжээрлэн хүрээлсэн байдалтайгаар оршино. Дунд зэргийн уулын гадаргуу нь районы баруун хэсэг дэх Улаан Хошуу уул болон Шар Чулуут уул юм. Энэ уулс нь 1223-1397 м үнэмлэхүй өндөртэй ба харьцангуй өндөршилт нь 100-150м байдаг. Голчлон доод эрт төрмөлийн настай хурдас тархсан. Улаан Хошуу уулын зүүн урд орших “Ар тамсаг-1-2” багтана. Үнэмлэхүй өндөр нь 1092 м

**Уур амьсгал, агаарын чанар:** Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилийн дундаж хэм нь  $+2.8^{\circ}\text{C}$  байдаг. Хамгийн хүйтэн сар нь 1-р сар ба агаарын хэм нь  $-37^{\circ}\text{C}$ , хамгийн дулаан сар нь 7-р сар ба агаарын хэм нь  $+40^{\circ}\text{C}$  хүрдэг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367.3 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80 % нь зуны улиралд бороо байдлаар ордог. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 367 мм-ээс хэтэрдэггүй ба үүний 80 % нь зуны улиралд бороо байдлаар ордог. Өвөл нь 5-25 см цасан бүрхүүл тогтож улирлын хөлдөлтийн гүн 2.5 м хүрдэг ба голчлон баруун өмнөөс 5-10 м/сек салхи салхилдаг. Заримдаа 20 м/сек хүрэх удаа бий.

**Усан орчин:** Ойр орчмын хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600 км-ын урттай 1-4 км өргөн хөндий бүхий урдаас хойш чиглэлтэй урсан өнгөрөх Туул гол юм. Голдирол тохойрол, тахирлалт ихтэй олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд голдирлын өргөн нь 30-100 м, гүн нь 0.5-1.6 м зарим газраа 2.5 м хүрдэг. Урсгалын хурд 0.3-1.1 м/сек, хөндийн хэвгий нь 0.001-0.002, голдирлын үнэмлэхүй өндөр нь ордын хэмжээнд доод хэсэгтээ 900 м, дээд хэсэгтээ 960 м хөндийн татмын хэсэгтээ талархаг юм. Туул голын голдирол нь тусгай зөвшөөрлийн талбайн баруун захаас 200-400 м зайтай урсан өнгөрдөг.

Газрын доорх ус агуулсан үе нь 6-30 м-ийн гүнд орших ба ойролцоогоор 3 л/сек ундаргатай байдаг.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбайд уулын хүрэн, аллювийн нугын, жинхэнэ хүрэн хөрс тархсан байна. Хээрийн судалгаагаар 6 цэгт хөрсний зүсэлт хийсэн. Хөрсний агрохимийн 6 дээж, хөрсний хүнд металл 2 дээж, эрүүл ахуй 1 задлан шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний үр дүнгээр дээж-1,5,6 дунд дээж-2,3,4 нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялмагийн агууламж дунд, цахилгаан дамжуулах чанар бага давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар бага байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дунд байна. Хүнд металлын агууламжаар MNS5850:2019-д заасан хөрсөнд агуулагдах хүлцэх агууламжаас бага буюу хэтрээгүй байна.

**Ургамлан нөмрөг:** Тухайн бүс нутаг нь ургамал газарзүйн мужлалтаар хувьд Евразийн хээрийн их муж, Дагуур-Монголын уулын ойт хээрийн муж, Орхон Сэлэнгийн дэд мужид хамаарна.

Төсөл хэрэгжих нутгийн хувьд газрын гадаргуу нь тэгширсэн газар, уулс хоорондын хотос, уулан дундах хотгор дахь бүтэц ул чулуулаг дээрх элэгдлийн суурьт тал толгодот, хөндийн ёроолоор, татмын нам дэнж үргэлжилнэ. Судалгааны талбайн нь уулын ойт хээрт 17 овгийн 48 төрлийн нийт 61 зүйл ургамал бүртгэгдсэн. Тэдгээр нь амьдралын хэлбэрийн хувьд сөөг 2, (3%), сөөгөнцөр 1, (2%), хагас сөөгөнцөр 3, (5%), олон наст өвс 56, (85%), ганц ба хоёр наст 6 (9%) зүйл ургамал байна. Ургамалын судалгаагаар дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээрийн 2 анги, 2 бүлэг төрөлд хамаарагдах 3 бэлчээрийн төрөл байна. Ховор ургамлын хувьд Алхил сонгино, Ацан ажигана зэрэг ховор ургамал бүртгэгдсэн.

**Амьтны аймаг:** Төсөл хэрэгжиж буй нутаг нь газарзүйн мужлалаар Монголын хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол Дагуурын тойрогт хамаарна. Энэ бүс нутагт махчин амьтдаас хярс, үнэг, өмхий хүрэн, гүйдлийн чанартай чоно, мануул байдаг. Мэрэгчдээс улирлын чанартай буюу өвөл ичдэг алагдаахай, оготно, зараа, алагдаахай, үхэр огодой, туулай тохиолдоно. Мөлхөгчдөөс элбэг түгээмэл шинжтэй нь могой, мэлхий байдаг бол шавьжнаас аалз, сохор хар, хэдгэнэ, царцаа, эрвээхэй болон бусад шулуун далавчтан байдаг. Жигүүртний хувьд болжмор, ногтруу, хадны тагтаа, элээ түүнчлэн хон хэрээ, бүргэд бусад шувуу амьдардаг.

**Нийгэм, эдийн засаг:** Хүн амын суурьшил нягт, голчлон газар тариалан болон мал аж ахуй эрхэлдэг, халх ястан голлон амьдардаг. Бүрэгхангай сумын хэмжээнд 2550 орчим хүн амтай, нийт хүн амын 33.3 % нь сумын төвд амьдардаг. Сумын хүн амын 31.8 % нь хүүхэд, 59 % нь залуу болон дунд насныхан, 9.05 % нь ахмад настан байна. Нийт хүн амын 51.5 % нь эмэгтэйчүүд, + 48.5 % нь эрэгтэйчүүд байна. Тус район нь зам харилцаа сайтай, өвөл, зуны аль ч улиралд бартаа саадгүй, аж үйлдвэр, ХАА-н үйлдвэрлэлийн баазуудад ойр байрлана. Тухайлбал Хөтөлийн цементийн үйлдвэрээс 170 км, Дархан хотоос баруун урагш 200 км-т, Улаанбаатар хотоос баруун хойш 245 км-т оршдог. Мөн газар тариалан, мал аж ахуй эрхэлдэг Бүрэгхангай сум 65 км, Заамар сум 50 км, Орхонтуул сум 35 км-т байрлана.

Талбайн аль ч хэсэгт хөдөлгөөнт холбооны Мобиком, Жи мобайл сүлжээний байнгын ажиллагаатай байна.

## БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### III.1. АГААРЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

Ил уурхайн ухаш овоолгоос үүссэн сул тоос агаарт дэгдэн тоосжилт үүсгэнэ.

#### Сөрөг нөлөөллийг бууруулах арга

- Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажлыг аль болох салхи багатай өдөр хийж гүйцэтгэх,
- Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх,
- Төслийн талбайг хаврын улиралд тогтмол усалж байх шаардлагатай,
- Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмол засвар, үйлчилгээг хийж байх.

### III.2. ГАЗРЫН ГАДАРГА БОЛОН ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, баяжуулах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн биш байдал, ШТМ алдагдах зэргээс хөрс бохирдох Ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаас үүдэн хөрсөн бүрхэвч бохирдох **Сөрөг нөлөөллийг бууруулах арга**

- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
- Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна), хяналт тавих,
- Тогтсон маршрутын дагуу замыг услах,
- Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах, нүхэн жорлонг халж, хөрсөнд үл нэвчин соруулдаг, эсвэл бага оврын цэвэршүүлэх байгууламж бүхий жорлонтой болох

- Машин механизмын засвар үйлчилгээ хийх үед санамсаргүй тохиолдлоор шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж засварын цех байрлах талбайг хатуу хучилттай болгох.
- Хөрсөн бүрхэвчид тодорхой давтамжтайгаар шинжилгээ хийн хянаж байх.

### III.3. Усны нөөцөд үзүүлэх нөлөө

Технологийн усан хангамжид гадаргын усыг ашиглах учраас гадаргын усны түвшин буурах, бохирдох нөлөөлөл байна.

Мөн газрын хөрсөнд ШТМ алдагдсанаар хөрсөнд нэвчин газрын доорх усыг бохирдуулах эрсдэл үүсэж болзошгүй.

#### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга**

- “Ар тамсаг-1-2” ордод ашиглах технологийн усан хангамжийг Туул голын уснаас татах бөгөөд ус дамжуулах шугам хоолойн эх дээр баталгаажуулсан тоолуур суурилуулан усны хэрэглээнд хяналт тавин ажиллах шаардлагатай.
- Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх.
- Эргэлтийн усан сангуудаас алт угаан баяжуулсан бохир ус хөрсөнд нэвчихээс сэргийлж эргэлтийн усан сангийн ёроолыг ус үл нэвчүүлэх тусгай зориулалтын зулхай, хулдаасаар хулдааслах шаардлагатай. Эргэлтийн усан сангаас ус алдаж болзошгүй тохиолдолд урьдчилсан арга хэмжээ авах, усан сангийн даланд хананы бэхлэгээ хийх, усан санг үерээс байнга хамгаалж байх.
- Машин механизмын засвар үйлчилгээ хийх үед санамсаргүй тохиолдлоор шатах тослох материал алдагдахаас урьдчилан сэргийлж засварын цех байрлах талбайг хатуу хучилттай болгох.

### III.4. УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдах, хог хаягдал, тоос тоосонцор салхиар дамжиж тархах болон хөрсөнд нэвчих байдлаар ургамал, хөрс, усыг бохирдуулах нөхцөл болох магадлалтай байна. **Сөрөг нөлөөллийг бууруулах арга**

- Олборлолт явуулсан талбайд устсан ургамлыг нөхөн сэргээж тарих,
- Шимт хөрсний овоолгыг тусад нь хуулж стандартын дагуу арчилж хадгалах
- Хавар намрын хуурайшилттай үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлж зурвас татах,
- Хог хаягдлыг нэгдсэн цэгт хуримтлуулж тогтмол зайлуулах, хог хаягдал салхинд хийсэхээс сэргийлж хогийн цэгийг хашаалах.

### III.5. АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

### **Эерэг нөлөөллүүд**

Амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

### **Сөрөг нөлөөллүүд**

Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй,

Олборлолт явуулж байгаа газарт болон усан санд мал, амьтан унах, хууль бус ан агнуур явагдах.

Хөрс хуулалтын үед үүссэн нүх, хөрсөнд орогнох, үүрлэх мэрэгч, мөлхөгч, шувуудын үүр ноохой сүйтгэгдэх зэрэг болно. **Сөрөг нөлөөллийг бууруулах арга**

- Уурхай болон усан сан орчмын талбайг мал амьтан унаж үрэгдэхээс сэргийлж хашаалах эсхүл хамгаалалтын далан байгуулах,
- Бүс нутгийн биологийн төрөл зүйл, тоо толгойг хамгаалах үүднээс орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөл, байгаль орчны албаны ажилтантай байнга хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт туслалцаа үзүүлэх, санал солилцох, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Хууль бус ан агнуур хийхгүй байх талаас уурхайн ажилчдад сургалт хийн, ухуулан таниулах, хяналт тавих ажлыг авч хэрэгжүүлэх.

### **III.6. ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛСТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

Түүх соёлын дурсгалт зүйлс нь ашиглалтанд өртөх талбайд илрээгүй байна.

Хэрэв ашигт малтмал ашиглалтын явцад хүн малын яс, шавар ваар савны хагархай, янз бүрийн хүрэл, төмөр эдлэл, түүний хэлтэрхий, хугархай гэх мэт хүний гараар хийсэн ямар нэг эд өлгийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд орон нутгийн удирдлага, БО-ны хяналтын улсын байцаагч, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж хамгаалалтанд авах ба дурдсан мэргэжлийн байгууллагад яаралтай хандаж малтлага судалгаа хийлгэхийг зөвлөж байна.

### **III.7. ТӨСЛӨӨС ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

### **Сөрөг нөлөөллийг бууруулах арга**

ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

### **III.8. Төслөөс нийгэм, эдийн засгийн байдалд үзүүлэх нөлөө**

Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр шинээр б\ий болгох, орон нутгийн иргэдээс мах сүү, цагаан идээ зэрэг уламжлалт аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг худалдан авах зэрэг эерэг нөлөөлөл байна.

## **БҮЛЭГ IV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

### **IV.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт**

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

### **IV.2. БОМТ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСЛЭЛ**

Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг

боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

### **IV.3. БОМТ-НИЙ БҮРДЭЛ ХЭСЭГ, АГУУЛГА**

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, Төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-г боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.

### **IV.4. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахад байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хөрөнгө зардал, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодитойгоор тооцож тусгалаа.

### **IV.5. БОМТ-НИЙ БҮТЭЦ**

БОМТ-ний бүрэлдэхүүнд 5 бүлэг, 7 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
